

МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ТҮҮХ, СОЁЛЫН ҮГ ХЭЛНИЙ БУС
МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Дагуул*

* ӨМӨЗО-ны Хөх хотын их сургуулийн профессор
Хөрвүүлсэн: Л.Норовсүрэн

Түлхүүр үг: монгол үндэстэн, түүх соёл, үг хэлний бус мэдээлэл, гарын дохио, дүр байдлын дуурайх хэл, хөдлөл барил, бодист түшиглэх, толгойн засал, халиу булга, эсгий гэр.

Агуулгын товч: зохиогч мэдээлэл зүйн зогсоцоос монгол үндэстний уламжлалт ёсон, зан үйл, түүх соёлд агуулагдаж байгаа дотоод далд мэдээ зангид шинжлэлт хийж, монгол үндэстний түүх соёлын үг хэлний бус мэдээллийг монголчуудын өдөр тутмын амьдрал дундах хөдлөл, барилаас бүрэлдсэн үг хэлний бус мэдээлэл, монгол хөгжим, бүжиг, зураг, найр наадам, ёслол зэрэг хөдөлгөөнөөр илрүүлсэн үг хэлний бус мэдээлэл, монголчуудын хувцас хунар, засал чимэг, сав хэрэгсэл, гэрч юм зэргийн үг хэлний бус мэдээлэл, монголчуудын бүтээн байгуулсан барилга ба үлгэр домогтой болгосон байгалийн үзэмж зэргийн илтгэсэн үг хэлний бус

мэдээлэл гэх дөрвөн төрлөөр ангилсан мөртөө бас түүний онцгой нэгэн мэдээллийн ажиллагаа болсны хувьдахь онцлог шинжийг хураангуйлан дурдсан байна.

Монгол нутаг уудам дэлгэр, баян чинээлгээрээ дэлхий дахиныг бахдуулж, ард түмэн нь эрэлхэг баатарлагаараа түүхэнд алдаршиж ирсэн юм. Тэрхүү онцгой байгалийн орчин тойрон, цаг уур, газар зүйн нөхцөл нь монгол үндэстний өвөрмөц цог заль ба зан заншлыг буй болгон үндэстний онцлогтоо тохирсон мэдээллийн хэлбэр, арга авцлыг бүрэлдүүлж, нийгмийн хөгжилт ба хүмүүн төрөлхтөнд хувь нэмрээ үзүүлсэн байна. Мэдээжээр үг хэлний бус мэдээлэл гэдэг бол зөвхөн ямар нэгэн мэдээ занги буюу мэдээг дамжуулахаас биш, харин тодорхой үгийг дамжуулдаггүй мэдээлэл болно. Нийгмийн амьдралын дунд үг хэлний бус мэдээллийн ажиллагаа маш өргөн дэлгэр тохиолдож байдаг. Хүмүүс

амьдралын дундаа санаачилгатай буюу санаачилгагүйгээр сэрэгдэл, зан ааш, үзэлт зэргээ илэрхийлэх үес, цөм мэдээллийн үйлдэл үүсэх боломжтой гэж хэлж болно. Бас мэдээлэл нь хүмүүсийн хоорондох харилцаа холбоо ойролцоод түшиглэн явагдахаас биш, зөвхөн үг хэлэнд л түшиглэх биш юм. Бид энд монголчуудын түүх соёл, зан дадгалаас гардаж монгол үндэстний үг хэлний бус мэдээллийн тойм байдал, төрөл зүйл, онцлог шинжийг задлан шинжилье.

Нэг. Монгол үндэстний үг хэлний бус мэдээллийн төрөл, зүйл

Хүмүүн төрөлхтний мэдээллийн ажиллагааны дэвшилт хөгжилт бол мэдээллийн хэрэгслийн дэвшилтээр гол бэлгэ тэмдэг болгож буй. Мэдээллийн үүсэл, хөгжилтийн явцыг шинжлэхэд мэдээллийн хэрэгслийн дэвшилт хөгжилтөөр гол сүвэгч болгож болно. Бүхий л хүмүүн төрөлхтний мэдээллийн ажиллагааны хөгжилттэй адилаар монгол үндэстэн ч анх ахин дахин чухам юугаар мэдээллийн хэрэгсэл болгож байсан тухай хэн ч зөв оновчтой, тодорхой хариулт өгөхөд төвөгтэй. Миний үзэхээр монгол үг хэл, үсэг бичиг буй болохоос өмнө монголчууд мөн нэгэн урт удаан мэдээллийн түүхэн явцыг өнгөрүүлсэн нь лавтай. Үүнийг бид үг хэлний бус мэдээллийн үе шат гэж тоймлон ярьж болох байна.

Эрдэмтдийн хамаа бүхий судалгаанаас үзвэл үг хэл, үсэг бичиг буй болохоос өмнө хүмүүн төрөлхтөн эл зүйлийн “дүр байдлын дуурайх хэл” буюу бодист түшиглэн дөхөм төд мэдээллийн ажиллагааг өрнүүлдэг байв. Хүмүүн төрөлхтний судлалын эрдэмтэн Морган “Эрт үеийн нийгэм”-дээ “хүмүүн төрөлхтний үг хэл нь хамаг бүдүүлэг, хамаг дөхөм илтгэх хэлбэрээс хөгжиж ирсэн мэт юм. Урьдаар үзэл санаа байж, дараа нь сая үг хэлтэй болох нь дамжиггүй. Үүнтэй адилаар урьдаар овор байдал буюу гарын дохиог хэрэглэн үгийн утгыг илтгэж, дараа нь сая тодорхой үет үг хэл буй болгох нь зайлшгүй” гэж бичив. Энд ярьж байгаа “хамгийн бүдүүлэг хамгийн дөхөмхөн илтгэх хэлбэр” ба үгийн утгыг илтгэхэд хэрэглэж байгаа “дүр байдал буюу гарын дохио” нь яг манай хэлдэг “дүр байдлын дуурайх хэл” болно. Дуурайх хэлний бодитой байдлын тухай бид нэгэнт мэдэхийн аргагүй боллоо. Гэвч үндэстний зарим үлдэгдэл, зан дадгал, хэв заншлаас түүний олон мөрийг олж харж болно.

Монгол үндэстний зан дадгал, хэв заншлаар түүх соёлыг үндэслэвэл Монголчуудын эрт үеийн нийгмийн үг хэлний бус мэдээллийг их төлөв дөрвөн төрөл зүйл хувааж болно. 1. Монголчуудын өдөр тутмын амьдрал дундах хөдлөл барилаас бүрэлдсэн үг хэлний бус мэдээлэл. 2. Монгол хөгжим, зураг,

бүжиг, найр наадам, ёслол зэрэг хөдөлгөөнөөр илрүүлсэн үг хэлний бус мэдээлэл, 3. Монголчуудын хувцас хунар, засал чимэг, сав хэрэгсэл гэрч юм зэргийн үг хэлний бус мэдээлэл, 4. Монголчуудын бүтээн байгуулсан барилга ба үлгэр домогтой болсон байгалийн үзэмж зэргийн илтгэсэн үг хэлний бус мэдээлэл болно. Өмнөх хоёр төрөл нь хүний биеэрээ хийсэн үг хэлний бус мэдээлэлд харьяалагдана. Хойнох хоёр зүйл нь хүмүүсийн бодист түшиглэн хийсэн үг хэлний мэдээлэлд харьяалагдана.

1. Монголчуудын өдөр тутмын амьдрал дундах хөдлөл барил нь зохих мэдээ зангийг мэдээлэх үйлдэлтэй байхыг ойлгоход тийм хүчир биш юм. Жишээлбэл: монголчуудын суух хэлбэр ёсонд цомцойж суух, завилж суух, сөгдөж суух, явган суух, сандайлж суух, хаяалдаж суух, алцайж суух мэт хэлбэр буй. Эдгээр суух хэлбэр ёс нь суугчийн овор суртал, нас жил, чанарын ялгал, биеийн гарал, нийгмийн байр суурь, эрх сүр, хэв боловсрол зэрэг талын баялаг мэдээ зангийг илрүүлж байдаг. Монгол гэрт суухад хүнийг хүндлэх, айлыг хүндэтгэх их хүнд ёс байдаг ажээ. Ямар зочин

болсон ч айлд ороод суунгуутаа заавал цомцойж суудаг ёстой. Орсон айл нь харц ядуу айл байсан ч, ноён баян айл байсан ч хамаагүй ирсэн зочин нь ахмад настан, төрийн түшээлтэн, төрөл садны алин байсан ч ялалгүй бүр л цомцойж сууна. Өөр янзаар суух ёсгүй. Цомцойж суухдаа гарын талаар суугчид ахлах тал болох зүүн өвдгөө нугалж цомцойн сууна. Зүүн тал ба хойт талд суугчид ахлах тал болох баруун өвдгөө нугалж цомцойн сууна. Ирсэн зочин цомцойн суухаар үл барам гэрийн хүмүүс ч зохчин ирээд ёсорхог суудлаар сууж байхад цомцойн суухаас бус өөр янзаар суух

«

Монголчуудын өдөр тутмын амьдрал дундах хөдлөл барил нь зохих мэдээ зангийг мэдээлэх үйлдэлтэй байхыг ойлгоход тийм хүчир биш юм. Жишээлбэл: монголчуудын суух хэлбэр ёсонд цомцойж суух, завилж суух, сөгдөж суух, явган суух, сандайлж суух, хаяалдаж суух, алцайж суух мэт хэлбэр буй.

»

ёсгүй. Ингэж төв ёсорхог суудлаар суудаг нь ирсэн зохин хийгээд гэрийн эзэн харилцан хүндэтгэж байгаагийн учир билээ. Ер нь цомцойж суух нь найрсаг ёсорхог төв суудал болохоор хүүхэд залуучууд нас ахмад хүний дэргэд бол гэртээ ч, айлд ч гэсэн цомцойж суухаас биш, өөр янзаар суудаггүй. Цомцойж суух нь эртнээс байжээ. Хамгийн наад зах нь Чингисийн үед ийм ёс байсан гэдгийг Нанхиадын Сүн улсын элчид "Зочныг дагасан нь эзнийхээ доор талд тус тус суулцана. Суухдаа цомцойж суухаас

биш, түшиглэх ба завилж суудаггүй” хэмээн тэмдэглэжээ. Энэ нь зочныг хүлээж авсны дараа төв суудлаар суух нь төрийн ширээнд ч ийм байжээ гэдгийг үзүүлж байгаа ажээ. Завилах бол чөлөөтэй тайвуухан, ихэмсэг суудал юм. Ийм хэлбэрээр ихэнхдээ төрийн түшээлтэн, нас ахимаг хүн л суудаг. Гэвч бүсгүй хүмүүс ерөөс завилж суудаггүй юм. Энэ нь гийчин зочин, гэрийн ахмад эр нөхрөө хүндэтгэх ёсноос уламжилж, нэгэнт заншил болсноос эдүгээ ч гэсэн бүсгүй хүн завилж суудаггүй ажээ. Харин үүний эсрэг лам хүн хэзээ ч, ямар газар ч ямар хүний дэргэд ч гэсэн ном уншиж суухдаа бүр л завилж суудаг ёстой билээ. Энэ нь бурхан багшийнх нь суудлын ёсноос шалтгаалсан биз ээ. Сөгдөж суух нь голдуу дээдэс ихэсийн дэргэд суух буюу өчиг мэдүүлэхэд суудаг суудал юм. Энгийн үед хүүхэд багачууд, нас залуу хүний сөгдөж суухыг дэмий ойшоохгүй боловч ахмад томоотой буюу дээр үеийн хүн, бэрүүд, охид, залуу хүмүүсийн дэргэд сөгдөж суухыг харин төвгүй гэж үздэг. Явган суух, хаяалдаж суух, алцайж суухыг ерөөс олигтой суудлаар үздэггүй билээ. Нэн ч алцайж суухыг ихэд жигшдэг. Гэрт явган суухыг ч цээрлэдэг. “Ядравч ташаагаараа битгий тул, яаравч явган бүү суу” гэдэг үг байдаг. Айлд ирсэн зочин явган суух байтугай гэрийнх нь хүн ч гэртээ явган суух ёсгүй билээ. Гэрт сууж байгаад эвшээх,

хэхрэхийг цээрлэдгээр барахгүй нэн ялангуяа гэрт исгэрэх, нуруу үүрэх нь айл өрх, гэрийн эзнийг хүнээр үзсэнгүй учир болох тул ийм байдал гаргахыг онц цээрлэдэг юм.

2. Монголчуудын хувцас хунар, толгойн засал, гоёлолын зүйл нь тэдний хөдлөл барилтай адилаар үлэмж олон мэдээ зангийг дамжуулах чадавхитай. Тэр нь ямар нэгэн хүний эрхэлсэн ажил, нийгмийн байр суурь, зан ааль, хэв заншил, дур сонирхол, соёл боловсрол, амьдралын дадгал, сүсэг бишрэл, үндэстний орны зан дадгал, онцлог зэргийг илрүүлж болно.

Монголчуудын бахархан өмсдөг монгол тэрлэг нь үндсэндээ өөрийн үндэстний хувцсаар суурь болгож, Умардын олон үндэстний хувцасны сайныг дуурайж өөрчлөн чимэглээд бүтээсэн байдаг. Хувилай хаан бол шинэчлэлийн үзлийг чанга баримталж, хувцас хунарын талаар ч урьдын удамшлыг залгамжилж, урагш хөгжихийг бодолхийлж, цаашлан “Ойр үеэс Алтан улс, Сүн улсынх, дээшид Хан улс, Тан улсынхыг шингээн авах”-ыг зорьсон байлаа. (“Юань улсын түүх, хувцасны тэмдэглэл”). Тэр үед тогтоосон нь: Ноёд бол магнаг торгон дээл, луу ороосон хатгамалтай. Ерийн хувцас нь Тан улсын хувцасны маягтай. Гэтэл монгол иргэдийн хувцас нь шар өнгөнөөс өөрийг бүр өмсөж болдог, дүрэм тогтоолд хязгаарлагдахгүй, хуучны заншлаар

өмсөж эдэлдэг. Харин монгол ноёд түшмэд бол өөр өөрийн зэрэг тушаалаар хэлбэр маяг, өнгө будгийг анхааран тогтоол ёсоор эдэлдэг байлаа. Монголын язгууртны эрэгтэй, эмэгтэйчүүд олон янзынхыг сонгож санаандаа тохирсон хувцас өмсөж болно.

Энэ нь даруй тухайн үед монгол үндэстэн хийгээд бусад үндэстний хоорондох язгууртан хийгээд эгэл ардын хоорондох, ноёд хийгээд ноёдын хоорондох хувцас хунарын өнгө будаг, хэлбэр маяг, хээ угалз, материалын талаар ихээхэн ялгаатай байсныг нарийн тодорхойлсон юм. Чин улсын үеийн монгол эмэгтэйчүүдийн өмсдөг тэрлэгийн янз маяг нь олон газар адилгүй. Буриад бүсгүйчүүдийн тэрлэг нь бүсэлхийгээрээ бачуу хийдэг. Ордос, Буриадын хувцас нь тэрлэг дээр ууж өмсөж, хорчины бүсгүйчүүд цув өмсөнө. Тэр мөртөө урагт мордсон эсэхийг хувцсаар нь таньдаг. Шилийн гол, Улаан цав аймгийн бүсгүйчүүд бүр бүс бүсэлнэ. Хорчин, Харчины эмэгтэйчүүд бүс бүслэхгүй. Эл газар орны монгол тэрлэгийн адил бус хэлбэр, онцлог нь тэрлэг өмсөгчийн аль хошуу, аймгийн хүн болох, гэрлэсэн эсэхийг сэм дохиолж байх юм. Монгол бүсгүйчүүдийн засал чимэг нь монгол ардын гоо сайхны нэгэн хэлбэр болно. Газар болгоны соёл урлагийн хэв намба өөр байж, толгойн эдлэл нь ч ондоо ондоо байдаг. Алшаа аймгийн засалд малгайн орой нь

гурван манах буюу эрдэнийн чулуугаар чимэглэгдэж, хоёр талын чихэнд нь өвчүү тултал навчилга хаддаг. Бас хар малгайд улаан хатгамал оёж өнгө ялгааруулна. Ордос эмэгтэйчүүдийн малгай нь орой дээрээ хуартай буюу гарьд шувууг зураглан оёсон байдаг. Малгайн доор талд нь хэлхсэн сувдаар чимэглэсэн зурагтай. Сураг дуулахад өнгөрсөнд сувдыг хэлхсэн тоогоор эзнийх нь баян эрхмийг үздэг гэнэ. Шилийн гол, Улаанцав аймгийн монгол бүсгүйчүүдийн малгай их төлөв оройг нь манах буюу ширээр тааруулан хийдэг мөртөө өмнөш унжийлгана. Толгойн засал ер нь мөнгөн хатгуур буюу эрдэнийн чулуу байдаг. Энэ нь бас өлзий бэлгэтэй, аливаа хэрэг сэтгэлчлэн бүтээхийг бэлгэдэж байгаа хэрэг юм.

3. Монгол ая хөгжим, бүжиг, найр наадам, үзлэг төлгө зэрэг ажиллагаа нь ч мэдээллийн үйлдэлтэй байдаг. Аль ч үндэстний хөгжим, бүжиг, соёл урлаг бол тухайн үндэстний ард түмний үзэл ойлголт, ухамсар танилтыг бодитойгоор тусган харуулсан байдаг. Жишээлбэл: монгол бүжиг, ая хөгжим зэрэг нь ч ард олны баяр баясал, уйтгар гуниг, санал мөрөөдөл, хүсэл зорилтыг илтгэдэг. Олны мэдээжээр хуурын үлгэрт аяс аялгуу элбэг байдаг. “Үлгэрийн ая” номд 200 гаруй зүйлийн аяыг эмхтгэн тэмдэглэжээ. Эдгээр олон аялгууг хуурч нар үлгэрийн агуулгадаа зохицуулан улируулан хувилгуулж хэрэглэ-

дэг. Тухайлбал "Баярт явдал дор баясгалант аяс, зовлонт явдалд нь эвхрэлт аяс, байлдах тулалдахад нь ширүүн аяс, уулзаж учрахад нь найрамдуу аяс, аялан явахад нь хөгжингүй аясуудыг тус тус хэрэглэдэг юм". Хуурчид аялгуу, агуулга хоёрыг энэ мэт ус, сүү шиг нэгдүүлж хэрэглэдэг тул хүмүүсийн сэтгэлийг татаж, аялгууг нь сонсвол агуулгыг нь төсөвлөж, агуулгыг нь сонсвол аялгууг нь магадалж, уул үлгэрийн үйл явдал, утга санааг нэвтрүүлэхэд маш их үүрэг гүйцэтгэсэн мөртөө гоо сайхны хүртээл олгодог байна. Үүнээс гадна эрт үеийн монголчууд бас багаж хэрэгсэл буюу ямар нэгэн бодисоор мэдээ зангийг мэдээлдэг. Жишээлбэл: монгол зан аашд эхнэр хүн хөвгүүн хөнгөжвөөс үүдэн дээрээ нум сумыг өлгөж, хөвгүүн хөнгөжсөн тэмдэг, охин хөнгөжвөөс үүдэн дээрээ ивийг өлгөж охин хөнгөжсөний тэмдэг болгомтой. Энэ нь нэг талаар гэрт сард сууж байгаа хүн байх бөгөөд хүү, хүүхний алиныг хөнгөжсөнийг бусад илэрхийлж, нөгөө талаар хөнгөжсөн тэмдэгтэй гэрт гаднаас орох хүн заавал анхаарч цээрлэх зүйлсийг гүйцэтгэж, ёс алдахыг хичээхийг анхааруулах мөртөө зарим хөнгөжсөн гэрт ордоггүй цээртэй хүмүүст дохио мэдээ хангах үйлдэлтэй. Монголчууд сав суулга, аяга тавагийг хүнд өгөхдөө дотор нь юм хийж ам, тагийг нь нээж өгдөг. Хоосон өгөх ёсгүй. Тэр нь элдэвт дүүрэн арвин байхыг

бэлгэдэж байх юм. Иймээс "сав дүүрэн, сааль нь арвин байг" гэх мэт үг буй болжээ. Үүнээс гадна эрт үеийн Монголчуудын байгуулан цогцлоосон ордон харш, орон сууц, хөшөө чулуу, овоо тахилга, жич шуумал, зурмал бурхны хөрөг, хүний хөрөг, жигүүртэн араатны дүр төрх зэрэг нь ч маш олон учир ёстой юм. Эсвэл тэдгээр нь зохих түүхэн уламжлал яриатай, эсвэл хөгжмийн хүмүүсийн тааруулсан үлгэр үйл явдалтай.

Ж ишээлбэл: монгол үндэстний орон сууцны дотор монгол гэр бол төлөөлөх чанартай юм. "Монголын нууц товчоон" дахь тэмдэглэлийг үндэслэвэл Чингис хаан мэндлэхээс өмнө монголчууд нэгэнт монгол гэрт суух болсон бөгөөд одоо хүртэл мянга гаруй жилийн түүхтэй болжээ. XIII зууны үед чiu чу жиэ Чан Чун бумба Чингис хааны урилгаар монголын өндөрлөгт хүрч ном талбихдаа монгол хүний хувцас ба орон сууцыг "Нүд нээмэгц халиу булгын арьс, эсгий гэр болой" гэж магтан шүлэглэж байсан юм. Монгол гэр нь ч маш гоёмсог юм. Юань улсын үед Чингис хааны алтан урагтны монгол гэр нь "Алтан дээвэр, алтан тулгууртай бөгөөд алтан гадасаар хадаж" байсан мөртөө хамгийн их нь хоёр мянган хүнийг багтаадаг. Үүнд монгол гэр гэх энэхүү өвөрмөц онцлогтой орон сууцнаас нь оршин суугчийн аль үндэстэн болох, ордон

харшийн сүрлэг сайхан, гоё эрхэмсгээс нь эрхэм язгууртан, эрх сүртэн байхыг мэдэж болох нь маш тодорхой байна. Олон зүйлийн үг хэлний бус мэдээллийн арга хэлбэрээс бид цул хувь хүний хоорондох үг хэлний бус мэдээлэл ба бүлэглэл цогцын хамтаар эдлэх үг хэлний бус мэдээллийг ялган үзэх хэрэгтэй. "Хөх сударт"-т ийм нэгэн үйл явдал буй. Найман улсын эзэн Даян хааны хөвгүүн Алтаншаа Полгодойн эхнэр Уранхүүгээр хэрэйд аймгийн Хэван (Хэрэйдийн хаан Тоорил – Л. Н.)-гийн охин Солонгоод нэгэн мушгиа таван өнгийн унгарил (мал, амьтны нарийн ноос, шувууны өрөвлөг – Л. Н.) торгон утсыг зангидан уясан эрхийвчийг хавтагад хийж өгсөнд Солонгоо эхлээд учир ухааныг нь олохгүй байснаа сүүлээр нь Алтаншаагийн дамжуулсан эрхэвч Солонгоо лугаа зангидмой" гэсэн андгай тангаргийн санааг ухав. Энэ бол цул хувь хүний хоорондох үг хэлний бус мэдээлэл болно. Мэдээллийн хэрэгслийн тэмдэг нь тогтмол бус, онцгой харьцаатай байдаг, тухайн хүнээс гаднах хүмүүс тайлан ойлгоход маш төвөгтэй.

Гэвч тэр дурьдсан хөдлөл барил, хувцас засал, нум сум, улаан хив мэт мэдээллийн хэрэгсэл бол түүх соёлын зан дадгалын хэлбэр мөн. Тэдгээрийн утга санааг бүлэглэл цогц хамтаараа ухан ойлгож байдаг. Уламжлалт чанар хийгээд дүрэмжлэлийн чанараар маш чанга юм. Тэгвэл

монгол үндэстний түүх соёлын үг хэлний бус мэдээлэл нь чухам ямар ямар ахуй байдал ба соёлын онцлог шинжтэй вэ?

Хоёр. Монгол үндэстний үг хэлний бус мэдээллийн онцлог шинж

Мэдээлэл нь нэг зүйлийн онцгой мэдээллийн ажиллагаа болсны хувьд түүнд зохих ахуй байдал ба соёлын онцлогтой юм. Монгол үндэстний түүх соёлын үг хэлний бус мэдээлэл нь үг хэлний мэдээлэлтэй тун төстэй. Тэр нь мөн зохих мэдээллийн утга санааг дамжуулж байдаг. Түүний хэлбэр нь заншлыг дагаж, дадлагыг журамладаг. Адил бус цаг үе үндэстэн, соёлын уламжлал ба газар оронд ялгаа зөрөөтэй байдаг. Түүний мэдээллийн тэмдэг нь цөм нэлээд тогтсон утгатай, тэмдгүүдийн хоорондоо зохих бүтцийн харилцаатай. Жишээлбэл: Ямар нэгэн ёслолын ажиллагаанд хүмүүсийн хөдлөл барил, үг яриа, хөгжим, бүжиг, хувцас хунар, багаж хэрэгсэл нь цөм тогтсон томъёолол бүтцээр зохион байгуулагддаг. Тэмдгийн бэлгэдэл утга нь үг хэлтэй адил, ёслолын дэс дараа нь хэл зүйтэй адил байж, тэмдгийн хоорондох дамжигдах дэс дараа нь бүхий л ёслолыг бүрэн бөгөөд холбогдох чанартай болгож буй. Монгол үндэстний түүх соёлын үг хэлний бус мэдээлэл бол монголчууд гэх энэхүү бүлэглэл цогцын уламжлалт зан

дадгал, соёлын амьдралаар мэдээллийн суурь болгодог. Аливаа тэмдэг ба түүний дэс дараа нь зөвхөн энэхүү соёлын ахуй байдалд л сая тайлбарлагдаж чадна. Зөвхөн тус соёлын хүрээнд байгаа хүмүүс сая тэдгээр үг хэлний бус мэдээллийн эчнээ далд утга санаа, учир ухааныг нь сэрэн ойлгож чадах бололцоотой. Харин тус үндэстний зан дад-

гал, соёлтой харьяа хамаагүй хүмүүс бол зөвхөн мэдээллийн цул гадар хэлбэрийг л сэрж мэддэг, яг л гадаад хэл мэдэхгүй хүн гадаадын хүний үг ярихыг сонсож байгаа мэт зөвхөн дуу аялгууны айзам цохилго, өргөлт даралтыг л сонсон, ам

хэлний хөдөлхийг л олж үзээд, түүний утга санааг ер нь ойлгож дийлэхгүй байдаг. Гэвч иймэрхүү үг хэлний бус мэдээлэл нь үг хэлний мэдээлэл, цаашлаад хувь хүний хоорондох үг хэлний бус мэдээлэлтэй чухал ялгаатай. Энэ нь даруй ёслол буюу зан дадгалтай төстэй мэдээллийн ажиллагаанд, чанга утга дээрх мэдээлэгч ба хүлээн авагч гэж оршихгүй байдгийг зааж буй. Бүгдээрээ хамтаар оролцон, хамтаараа сонирхох ба мэдэрдэг. Хүн бүр уламжлалт дадгалаар ажиллад-

гаас ямар ч тодорхойлолт тайлбарлал хэрэггүй. Иймээс мэдээллийн ахуй байдалд үг хэлний ухагдахуун нь илүүц байдаг. Оюунч магадлал ч хэрэггүй. Дүр төрх, сэрэл, сэтгэлээ бол сая хүмүүсийн хоорондох жинхэнэ нэвтрэлцэх хөөрөг болдог байна.

Монгол үндэстний түүх соёлын үг хэлний бус мэдээллийг чадавхийн та-

лаас яривал шинэ мэдээ зангийг солилцох нь гол биш, харин тогтсон нийгмийн харьцаа, зэрэг дэс, эмх журам, итгэл баримжаа, ёс суртахууны дүрэмжил ба бүлэглэл цогцын хүслэнг дахин илэрхийлэх нь чухал байна. Аливаа дахин илэрхийлэл нь бүр элдэв

«
Мэдээлэл нь нэг зүйлийн онцгой мэдээллийн ажиллагаа болсны хувьд түүнд зохих ахуй байдал ба соёлын онцлогтой юм. Монгол үндэстний түүх соёлын үг хэлний бус мэдээлэл нь үг хэлний мэдээлэлтэй тун төстэй. Тэр нь мөн зохих мэдээллийн утга санааг дамжуулж байдаг. Түүний хэлбэр нь заншлыг дагаж, дадлагыг журамладаг. Адил бус цаг үе үндэстэн, соёлын уламжлал ба газар оронд ялгаа зөрөөтэй байдаг.

»

зүйлийн ёслол үйлийн ард далдлагдаж буй. Хамаг эцэст ёслол үйлээр дамжиж, нийгмийн гишүүнийг уяруулан ухааруулж, тэдний соёл сэтгэцийн талаарх зөвшөөрлийн сэтгэлгийг аяндаа үүсгэж, нийгмийн бүлэглэл цогцын төвлөрлийг чангатгадаг. Нийгмийн гишүүн хувь хүний талаас яривал тэдний хоорондох бие сэтгэлээр оролцох дэс дараа ба хэмжээний зөрөөнөөс болж мэдээллийн үр бүтээмж нь адилгүй. Гэвч ерөнхийд нь үзвэл иймэрхүү үг хэлний бус мэдээлэл нь ер нь

зорилгодоо хүрч чаддаг. Монголчуудын эрт үеийн уламжлалт соёл урт хугацаагаар залгамжлагдаж, үндэстний соёл сэтгэцийн хэв чанар уламжлагдан байгаа нь иймэрхүү үг хэлний бус мэдээлэлтэй тун их харьцаатай байна. Дахивал дадгалжиж, ёслолчилсон үг хэлний бус мэдээлэл нь бүрэлдмэгц түүний "бүтэц-чадавхи" нь их төлөв тотворжчихдог.

Зарим үес хэдийгээр газар орны байдалдаа тохируулж яршиг төвөгтэй буюу дөхөм төдөөр зохицуулдаг боловч мөнхүү түүний уг санааг хөндөхгүй юм. Нэгэн уламжлалт нийгэмд өсөн бойжсон хүнд авч хэлбэл төрсөн тэр өдрөөсөө эхлэн маш олон ёслол журам, зан заншлын ажиллагаанд оролцож, нийгмийн соёлоос шим

тэжээл хүртдэг. Үүгээр дамжин үг хэлний бус мэдээлэл нь нийгмийн гишүүн нэг бүрийг сурган хүмүүжүүлэх үйлдлээ ихээр бадруулдаг.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Галиндар*. 1990. Монгол гэрийн уламжлалт ёсон. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.

2. *Хөхбуян*. 1988. Монголын зан үйлийн мөрдөл. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо.

3. *Оч*. 1999. Монгол аман зохиолын удиртгал. Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо.

4. *Лувсанчойдан*. 1981. Монголын зан үйлийн ойлбор. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.

5. *Одбагмид Ц*. 1986. Монголын ардын хүндлэх, мэндлэх, талархах ёс. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

6. *Инжиннаши В*. 1979. Хөх судар (тэргүүн дэвтэр).